

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 04 дугаар
сарын 20 -ны өдөр

Дугаар А/49, А/105

Улаанбаатар хот

Тэтгэвэр тогтоолгоход баримтлах ажил, мэргэжлийн
жишиг цалингийн хэмжээ батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэхь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тэтгэвэр тогтоолгоход баримтлах ажил, мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ"-г нэгдүгээр хавсралтаар, "Ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход баримтлах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Мөнхзүл/-т, Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлого, зохицуулалтын газар /Б.Алимаа/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалыг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН



ХӨДӨЛМӨРИЙН САЙД



Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны 04 дугаар сарын 20 -ний өдрийн А/49, А/105 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

**ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД БАРИМТЛАХ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН
ЖИШИГ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

/төгрөгөөр/

	Үндсэн бүлэг	1990 он ба түүнээс өмнөх	1991 он	1992 он	1993 он	1994 он
1	Менежер	750	1500	2700	7000	12600
2	Мэргэжилтэн	600	1200	2150	5600	10100
3	Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	530	1060	1900	4960	8950
4	Контор, үйлчилгээний ажилтан	400	800	1440	3750	6750
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	380	760	1370	3550	6400
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	370	740	1330	3450	6250
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	460	920	1650	4300	7750
8	Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	500	1000	1800	4700	8400
9	Энгийн ажил, мэргэжил	300	600	1100	2800	5050
0	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	550	1100	1980	5150	9250

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ,
ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**

Хүн амын хөгжил, нийгмийн
хамгааллын сайд, Хөдөлмөрийн
сайдын 2016 оны 04 сарын 20-ны
өдрийн 1/49, А/ дугаар хамтарсан
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИНГ ҮНДЭСЛЭН ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСИЙГ ТОДОРХОЙЛОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох даатгуулагч, иргэний сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. "Ажил, мэргэжлийн жишиг цалин" гэж Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын "Тэтгэвэр тогтоолгоход баримтлах ажил, мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ батлах тухай" 2016 оны 1/105 дугаар хамтарсан тушаалаар тогтоосон цалингийн хэмжээг ойлгоно.

1.3. "Ажил, мэргэжил" гэж тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт бичигдсэн ажил, албан тушаалыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан "Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт "YAMAT"-08"-ыг баримтлан тодорхойлсныг хэлнэ.

1.4. Нийгмийн даатгалын төв байгууллага нь тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний эрхэлж байсан ажил, мэргэжил нь энэхүү журмын 1.3.-д заасан "Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт YAMAT-08"-ын жагсаалтад байхгүй бол тухайн ажил мэргэжлийг хэрхэн шийдвэрлэх асуудлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Хоёр. Ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэх

2.1. Дараах тохиолдолд ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлно. Үүнд:

2.1.1. "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль", "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль" (цаашид хууль гэнэ)-ийн дагуу тэтгэвэр тогтоолгоход тухайн даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох цалин хөлсний баримт нь архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байснаас шалтгаалан тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэврээ тогтоолгосон бол;

2.1.2. 1995 оноос өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо сонгон хуулийн дагуу тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан боловч тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь архивын баримтаар нотлогдохгүй байгаа бол;

нотлогдохгүй байгаа бол эдгээр саруудын хөдөлмөрийн хөлсийг ажил, мэргэжлийн жишиг цалингаар тооцож болно.

Санамж¹ Иргэн "А" нь Гутлын үйлдвэрийн даргаар ажиллаж байсан үеийн 1988-1992 оны хөдөлмөрийн хөлсийг сонгон тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан. Гэвч "А"-гийн 1989 оны 5,6 дугаар сард авч байсан цалин хөлс нь архивын баримтаар нотлогдоогүй бол 1989 оны 5, 6 дугаар сарын цалинг "Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт "YAMAT"-08"-ын "менежер" гэсэн үндсэн бүлэгт хамааруулан ажил, мэргэжлийн жишиг цалинг тогтоосон шийдвэрт зааснаар 1990 оноос өмнөх учир 5,6 дугаар сарын цалинг 750,0 төгрөгөөр дүйцүүлэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-д заасны дагуу тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг тодорхойлно.

2.2. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нөхөн тооцох тухай хуулийн дагуу тэтгэвэр авагч, даатгуулагч 1995 он хүртэл хугацаанд ажилласан жилээ нөхөн тооцуулсан бол тухайн хугацааны ажил мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлсний дунджийг тодорхойлоход хэрэглэхгүй.

2.3. Авч байгаа тэтгэврийг нь тогтоохдоо хөдөлмөрийн хөлсийг үндэслэн тэтгэвэр тогтоолгосон бол тухайн тэтгэвэр авагчийн тэтгэврийг ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэн өөрчлөн тогтоохгүй.

Гурав. Ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоох

3.1. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоолгох тухай өргөдлөө оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад бичгээр гаргана.

3.2. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн нь 1995 оноос өмнөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох цалин хөлсний баримт гаргах боломжгүй тухай архивын байгууллагын лавлагаа авсан байна.

3.3. Нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг хүлээн авч "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль", "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн холбогдох заалтыг тус тус үндэслэн тэтгэврийг тогтоож, олгоно.

3.4. Энэ журмын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоохдоо Засгийн газрын 2015 оны 52 дугаар тогтоолын 1-д заасныг баримтална.

3.5. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний тэтгэврийг тогтоохдоо зөвхөн ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлах бөгөөд бусад цалин хөлсөнд хамаарах нэмэгдлийг тэтгэвэр бодоход баримтлах хөдөлмөрийн хөлсний бүрэлдэхүүнд оруулан тооцохгүй.

3.6. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний ажил, мэргэжлийн жишиг цалинг "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан 5 жилийг баримтлан тодорхойлно.

3.7. Тухайн тэтгэвэр авагчийн тэтгэврийг ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн шинэчлэн тогтооход анх тогтоосон тэтгэврээс буурахаар байвал хуучин тэтгэврийг үргэлжлүүлэн олгоно.

3.8. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага нь тэтгэвэр авагч, даатгуулагчийн жишиг цалингаар тэтгэврээ тогтоолгох тухай өргөдлийг холбогдох баримт, бичгийн хамт хүлээн авч тэтгэвэр тогтоож, олгох ажлыг "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 28 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулна.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүрэг бүхий бусад байгууллага хяналт тавина.

4.2. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.